

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкны “А” байрны хаалга шинэчлэх ажил гүйцэтгэх  
Тендер шалгаруулалтын дугаар: DR-2016/01

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос Монголбанкны “А” байрны 1 дүгээр давхрын хаалгыг шинэчлэхтэй холбогдсон буулгалт, шинэчлэлтийн болон холбогдох засварын ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 (дансны нэр: тендерийн хороо) тоот дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: 130,000,000.00 төгрөг

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 130,000,000.00 төгрөг

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2014, 2015 он

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 130,000,000.00 төгрөг

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Барилгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дvнтэй тендерийн баталгаа ирvвлнэ ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### МОНГОЛБАНК

*Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “А” байрны 1 давхар 2 тоот өрөө,  
Утас: 310633, 327048, Факс: 311471*